



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ-2018/151/СТА-ТШЗ

2018 он



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.02.23 № 06/534
танай -ны № -т

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ Д.НЯМХҮҮ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн вөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим стандарт болон Аудитын олон улсын стандартад түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөх байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хётлэлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дунд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланда тусгасан болно.


Үүрэг, хариуцлагын талаархи мэдээлэл

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *В.М.* Ц.НАРАНЧИМЭГ

2018.01.22





ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

САГ-ын захирал бөгөөд
тэргүүлэх аудитор:
Ц.Наранчимэг Утас:261663
Цахим хаяг:
naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер:
Я.Самбууням
Утас:261885
Цахим хаяг:
sambuunyamya@audit.gov.mn

Аудитор: Б.Долгоржав
Утас: 260512
Цахим хаяг:
dolgorjavb@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний
аудитын газар
Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

2018 оны 2 дугаар сар

САГ-2018/151/СТА-ТШЗ

Аудитын тайлан

- Хавсралт 1: Агуулга
- Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
- Хавсралт 3: Менежментийн захидал
- Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

01

ТЕРИЙН АУДИТИН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДУТНЭЛТ

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зерчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланда /УАГ-САГ/2018/151/СТА-ТШЗ/ аудит хийлгээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайланда Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 25-наас 2018 оны 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн аудитын менежер Г.Цэдэнбалжираар хянуулан Дундманхайдай аудит ХХК-ны аудитор Д.Уртнасан, туслах аудитор Б.Жаргалсайхан нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Халдварт өвчин судлалын үндэсний төв 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2018 оны 1 дүгээр сарын 25-нд Дундманхайдай аудит ХХК-д ирүүлсэн байна.

Дундманхайдай аудит ХХК аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 25-наас 2018 оны 2 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 25-нд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Ерөнхий захиралд гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын багц хуулиуд, Хувь хүний орлогын албан татварын хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Байгууллагын үйл ажиллагааны зорилтыг “Олон улсын эрүүл мэндийн дүрэм, халдварт өвчинтэй тэмцэх Ази Номхон далайн бүсийн стратегийн шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан, Шинжлэх ухаан техникийн дэвшил, хүний нөөцийн тогтвортой хөгжлийг дэмжигч байгууллага байна” гэж тодорхойлсон байна.

Тус төв нь хүн амын эрүүл мэнд, нийгэм, эдийн засагт халдварт өвчиний учруулж болзошгүй аюул, эрсдлийг бууруулах, халдварт өвчинийг тандах, сэргийлэх, оношлох, эмчлэх, эрдэм шинжилгээ, сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр үндэсний түвшинд хэрэгжүүлэх үүрэг бүхий тусгай мэргэжлийн байгууллага юм.

Мөн Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захидал нь төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжуулсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дун:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансадад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 11 горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бodoх бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Халдварт өвчин судлалын үндэсний төв санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баттуулж, 2017 оноос эхлэн мөрдөн ажиллаж байна.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд "Бага" буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед "Бага" гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Халдварт өвчин судлалын төвийн төсвийн захирагч нь 2017 оны жилийн эцсийн байдлаар улсын төсвееес урсгал зардалд 16,769,309.9 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 984,661.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, бараа үйлчилгээний орлогоор 170,504.9 мянган төгрөгийн орлого олжээ. Үүнээс урсгал зардалд 17,995,890.2 мянган төгрөг батлагдсанаас 17,924,476.0 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 71,414.2 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан талаар тодорхой тусгах үүрэгтэй. Шилэн дансны тухай хуулийн дагуу байршуулан ил тод, нээлттэй мэдээлсэн байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 18 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 17 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Халдварт өвчин судлалын төвийн төсвийн захирагч нь 2017 оны жилийн санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланда нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бусад орлого, төлбөр хураамж, сургалт семинар зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 29.4 хувь, мөнгөн хөрөнгийн 1.1 хувь, нийт зардлын 6.3 хувь, нийт хөрөнгийн 43.0 хувийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1.Кассын орлогын ордерыг урьдчилан дугаарлан хүлээлгэж өгөөгүй нь үйл ажиллагааны орлого дутуу тусгагдах эрсдлийг үүсгэж байна.

Иймд мөнгөн кассын өдөр тутмын үйл ажиллагаа, өөрийн орлогын төвлөрүүлэлтэд хяналт тавих, эмнэлгийн үйлчилгээг хэрэглэгчдэд түргэн шуурхай хүргэх, цахим бүртгэлийн програмыг нэвтрүүлэх шаардлагатай байна.

Эн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх,” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мөнгөн кассын өдөр тутмын үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах үүднээс хэрэглэгчдэд түргэн шуурхай

САГ-2018/151/СТА-ТШ3



хүргэх, цахим бүртгэлийн программ хангамжийг нэвтрүүлэх асуудлыг зохих шатны байгууллагуудад уламжилж шийдвэрлүүлэх талаар аудитын зөвлөмж өгөх.

2. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр 2017 онд 93.165.2 мянган төгрөгийн үнэ бүхий MKF-074 маркийн хөргөгч 20, MK304 маркийн хөргөгч 20 ширхэгийг тус тус хүлээн аваходаа бараа материалын дансанд тусгасан, харин урд онд хүлээн авсан MK304 маркийн 7 ширхэг хөргөгчийг үндсэн хөрөнгөнд тусгажээ.

2017 онд эдгээр хөрөнгүүдийг эрүүл мэндийн байгууллагуудад шилжүүлэхдээ урд онд 2,176.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон, ижил төрлийн хөрөнгүүдийг 2 өөр хөрөнгийн Үндсэн хөрөнгө, Бараа материалын/дансдад бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Урд онд элэгдлийн зардалд 2,176.0 мянган төгрөгийг тооцсон нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлын хэмжээг өсгөж, байгууллагын орлого үр дүнгийн тайланд нөлөөлсөн алдааг запруулах бичилт хийлгэлээ.

3.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд хөрөнгүүдийг хуваарилах явцад гарах алдаа зөрчлийг арилгах үүднээс санхүүжүүлэгч байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулах данс бүртгэлд үнэн зөв тусгах ажлуудыг нэгдсэн удирдлагаар хангах, эрүүл мэндийн бусад байгууллагуудад хөрөнгө хуваарилах явцад хяналт тавих шаардлагатай байна.

Глобаль сангийн хөрөнгийн санхүүжилтээр ирж буй зарим хөрөнгүүдийг анхан шатны бүрдэл дутуу баримтаар бүртгэлд авсан байна.

Энэ нь санхүүжүүлэгч байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулаагүйгээс төсөл, арга хэмжээний хүрээнд хөрөнгүүдийг хүлээн авах, хуваарилах явцад хөрөнгө дутагдах, данс бүртгэлд тусгагдахгүй үлдэх эрсдэлтэй байна.

Шийдвэрлэсэн: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд хөрөнгүүдийг хуваарилах явцад гарах алдаа зөрчлийг арилгах үүднээс санхүүжүүлэгч байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулах данс бүртгэлд үнэн зөв тусгах ажлуудыг нэгдсэн удирдлагаар хангах, эрүүл мэндийн бусад байгууллагуудад хуваарилагдах хөрөнгүүдийг бараа материалын дансдад бүртгэх талаар зөвлөмж өгөх

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Залруулагдаагүй алдаа байхгүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2017 оны жилийн эцсийн байдлаарх санхүүгийн тайлангийн аудитын явцад Гадаадын зээл, тусlamжийн хөрөнгөөр бэлтгэгдсэн хөрөнгийн хүлээн авах, хуваарилах үйл ажиллагаатай хамаарал бүхий ажил гүйлгээг мөшгин шалгаж амжаагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2017 оны жилийн эцсийн байдлаарх санхүүгийн тайланд хийсэн аудитаар 2,176.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч ажиллалаа.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд "Ас арвай-аудит" ХХК-ний хийсэн аудитаар 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

АУДИТЫН ТАЙЛАНС

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Г.ЦЭДЭНБАЛЖИР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Д.УРТНАСАН

**ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2017 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1
Үндсэн хөрөнгө.....1

Асуудал 2
Мөнгөн хөрөнгө3

2018 оны 2 дугаар сар

САГ-2018/151/СТА-ТШЗ



Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга нь АОУС-ын дагуу хийгддэг Төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Халдварт өвчин судлалын үндэсний төвийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Үндсэн хөрөнгө**Тэргүүлэх ач холбогдол №1****ҮАГ-ын ажиглалт**

2017 онд эдгээр хөрөнгүүдийг эрүүл мэндийн байгууллагуудад шилжүүлэхдээ урд онд 2,176.0 мянган төгрөгийн элэглийн зардал тооцсон, ижил төрлийн хөрөнгүүдийг 2 өөр хөрөнгийн /Үндсэн хөрөнгө, Бараа материалын/ дансадад бүртгэсэн байна.

Глобаль сангийн хөрөнгийн санхүүжилтээр ирж буй зарим хөрөнгүүдийг анхан шатны бүрдэл дутуу баримтаар бүртгэлд авсан байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд хөрөнгүүдийг хуваарилах явцад гарах алдаа зөрчлийг арилгах үүднээс санхүүжүүлэгч байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулах данс бүртгэлд үнэн зөв тусгах ажлуудыг нэгдсэн удирдлагаар хангах, эрүүл мэндийн бусад байгууллагуудад хөрөнгө хуваарилах явцад хяналт тавих шаардлагатай байна.

Энэ нь санхүүжүүлэгч байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулаагүйгээс төсөл, арга хэмжээний хүрээнд хөрөнгүүдийг хүлээн авах, хуваарилах явцад хөрөнгө дутагдах, данс бүртгэлд тусгагдахгүй үлдэх эрсдэлтэй байна.

Эрсдэлүүд

Хөрөнгө үрэгдэх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх,

ҮАГ-ын зөвлөмж

Гадаадын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгийг хүлээн аваадаа хөрөнгүүдийг ангиллын дагуу бүртгэж, дахин хуваарилагдах хөрөнгүүдийг аж ахуйн материалын дансаар дамжуулан санхүүжүүлэгч байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулан данс бүртгэлд тусгаж байх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 6 дугаар сарын 10-ны дотор ҮАГ-т ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно

Асуудал 2: Мөнгөн хөрөнгө**Тэргүүлэх ач холбогдол №2****ҮАГ-ын ажиглалт**

Мөнгөн кассын өдөр тутмын гүйлгээнд хөтөлгөддөг анхан шатны баримт болох кассын орлогын ордерыг урьдчилан дугаарлан мөнгөн кассын няравт хүлээлгэж өгөөгүй байгаа нь үйл ажиллагааны орлого дутуу тусгагдах эрсдлийг үүсгэж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, дугаар сарын 10-ны дотор ҮАГ-т гүйлгээг бүртгэхгүй байх;" гэж заасантай ирүүлэх нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Мөнгөн кассын өдөр тутмын үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах үүднээс эмнэлгийн үйлчилгээг хэрэглэгчдэд түргэн шуурхай хүргэх, цахим бүртгэлийн програм хангамжийг нэвтрүүлэх асуудлыг зохих шатны байгууллагуудад уламжилж шийдвэрлүүлэх

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 6 дугаар сарын 10-ны дотор ҮАГ-т гүйлгээг бүртгэхгүй байх;" гэж заасантай ирүүлэх нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, авлага өр төлбөр санхүүгийн тайланда буруу тусгагдах, өр төлбөр үүсэх нөхцөл бүрдэх.


Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2017 он 12 сар 31 өдөр.

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/ төгрөгөөр /
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,950,715,992.33	8,163,008,222.90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.0	0.0
33	АВЛАГА	234,331,740.00	233,393,300.00
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	234,331,740.00	233,393,300.00
33300	Татаас санхүүжилт	200,038,840.00	199,100,400.00
33500	Бусад авлага	34,292,900.00	34,292,900.00
35	БАРАА МАТЕРИАЛ	9,439,666,056.97	7,929,614,922.90
35100	Түүхий эд материал	9,326,067,029.94	7,556,078,391.98
35110	Тусгай зориулалттай материал	631,724,726.20	853,946,529.16
35130	Эм боох материал	8,694,342,303.74	6,702,131,862.82
35400	Хангамжийн материал	113,599,027.03	116,671,287.76
35410	Бичиг хэргийн материал	9,734,943.15	9,060,946.50
35420	Аж ахуйн материал	39,907,040.24	71,902,774.58
35430	Сэлбэг хэрэгсэл	4,510,200.00	5,328,200.00
35440	Түлш, шатах тослох материал	2,955,000.00	3,397,000.00
35460	Хүнсний материал	50,029,594.64	26,922,366.68
35470	Бусад хангамжийн материал	6,402,249.00	
35600	Мал, амьтад	60,000.00	60,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	276,718,195.36	256,865,243.16
36600	Бусад нөөц	276,718,195.36	256,865,243.16
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	13,584,403,560.01	12,531,073,829.18
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	13,584,403,560.01	12,531,073,829.18
39200	Биет хөрөнгө	13,584,306,337.69	12,526,634,940.14
39201	Барилга, байгууламж, орон сууц	19,906,688,928.00	19,906,688,928.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(10,397,060,606.15)	(10,909,009,214.87)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,205,169,054.00	1,205,169,054.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(816,060,731.05)	(981,686,054.40)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	8,947,702,108.10	8,745,196,313.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	(5,779,017,216.24)	(5,955,520,330.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	960,020,967.09	991,912,836.47
39208	Хуримтлагдсан элэгдэл	(654,280,267.31)	(677,130,219.05)
39209	Зам, гүүрийн байгууламж	237,315,782.00	237,315,782.00



ТӨРКИЙН АУДИТИЙН БАЙГУУЛАГА
ЗӨВЧИЙН САНАЛ ДУГНЭЛТ

39210	Хуримтлагдсан элэгдэл	(35,011,241.06)	(44,144,852.78)
39217	Ном	8,839,560.31	7,842,697.31
39300	Биет бус хөрөнгө	97,222.32	4,438,889.04
39301	Програм хангамж	6,274,750.0	10,774,750.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,177,527.68)	(6,335,860.96)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	23,535,119,552.34	20,694,082,052.08
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0.00	22,567,948.65
	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0.00	22,567,948.65
413	Өглөг	0.00	22,567,948.65
4131	Ажилчидтай холбогдсон зардал	0.00	22,567,948.65
4132	Барaa үйлчилгээний зардлын өглөг	-	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	23,535,119,552.34	20,671,514,103.43
51	Засгийн газрын хувь оролцоо	9,674,240,769.60	9,674,240,769.60
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	9,674,240,769.60	9,674,240,769.60
51200	Хуримтлагдсан үр дүн	7,388,925,499.31	4,549,479,911.43
51210	Өмнөх үеийн үр дүн	4,213,685,479.15	7,413,085,360.34
51220	Тайлант үеийн үр дүн	3,175,240,020.16	(2,863,605,448.91)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.0	
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,471,953,283.43	6,447,793,422.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	23,535,119,552.34	20,694,082,052.08

01


ТЕРИЙН АУДИТИН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2017 он 12 сар 31 өдөр.

/ төгрөгээр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	34,416,663,745.10	31,449,497,114.84
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,445,721,601.34	12,015,914,253.16
120	Нийтлэг татварын бус орлого	12,445,721,601.34	12,015,914,253.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,445,721,601.34	12,015,914,253.16
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	404,215,551.00	155,603,803.01
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,466,290.79	25,978,415.04
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,008,039,759.55	11,834,332,035.11
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	21,970,942,143.76	19,433,582,861.68
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	16,348,549,700.00	16,769,309,900.00
131001	Ургал үйл ажиллагааны санхүүжилт	16,348,549,700.00	16,769,309,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,034,492,443.76	1,679,611,761.68
131101	Төрийн болон орон нутгийн өмчтэй бус этгээдээс авсан хандив, тусламж	4,110,122,420.76	1,401,818,173.68
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		196,127,881.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	924,370,023.00	81,665,707.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	587,900,000.00	984,661,200.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	587,900,000.00	984,661,200.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	31,241,423,724.94	20,896,057,088.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,241,423,724.94	20,896,057,088.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,990,150,992.33	20,635,611,139.79
2101	Цалин хэлс болон нэмэгдэл урамшил	9,801,378,986.65	10,230,101,045.76
210101	Үндсэн цалин	9,691,659,316.65	10,019,345,869.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	109,719,670.00	210,755,176.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,137,775,458.76	933,493,879.89
210201	Тэтгэврийн даатгал	665,862,771.71	587,489,051.60
210202	Тэтгэмжийн даатгал	76,098,601.82	82,520,924.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	188,518,898.06	81,648,727.48
210204	Ажилгүйдлийн даатгал	18,845,017.11	16,521,770.71
210205	Эрүүл мэндийн даатгал	188,450,170.06	165,313,406.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	862,879,800.00	983,978,820.00
210301	Гэрэл, цахилгаан	327,904,090.57	357,537,094.00
210302	Түлш, халаалт	269,891,860.43	315,289,406.00
210303	Цэвэр, бохир ус	265,083,849.00	284,446,400.00
210304	Байрны түрээс		26,705,920.00
2104	Хангамж, бараа материалын зардал	951,370,153.18	659,285,531.25
210401	Бичиг хэрэг	139,740,543.00	145,994,056.65
210402	Тээвэр, шатахуун	624,471,077.99	300,281,369.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	22,704,278.54	24,657,705.74
210404	Ном, хэвлэл	54,000.00	19,735,000.00
210405	Хог хаягдал зайлцуулах, хортон мэргэчдийн устгал, ариутгал	62,854,310.00	58,247,815.50



210406	Бага үнэтэй, түргэн элзгдэх, ахуйн эд зүйлс	101,545,943.65	109,372,721.36
210408	Бараа материал актальны зардал		996,863.00
2105	Нормативт зардал	5,227,014,649.85	5,508,526,010.92
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,491,942,449.17	4,735,331,772.96
210502	Хоол, хүнс	727,893,839.68	773,119,237.96
210503	Нормын хувцас, зөвлөн здлэл	7,178,361.00	75,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	81,054,125.22	227,052,848.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,356,200.00	12,014,480.00
210602	Тавилга	4,176,440.00	3,905,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,960.00	12,008,850.00
210604	Урсгал засвар	74,509,525.22	199,124,518.00
2107	Томилолт, зочны зардал	541,399,297.00	298,597,250.00
210701	Гадаад албан томилолт		44,940,200.00
210702	Дотоод албан томилолт	541,399,297.00	253,657,050.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	470,172,166.00	271,425,403.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	454,740,712.00	255,963,485.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	3,872,148.00
210803	Даатгалын үйлчилгээ	939,384.00	1,057,270.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,971,700.00	2,160,900.00
210805	Тээврийн хэрэгслийн иношлогоо	64,170.00	
210807	Газрын төлбөр	8,456,200.00	8,371,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,917,106,355.67	1,523,150,350.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,567,455,210.52	10,417,160.00
210903	Үндсэн хөрөнгийн элзгэл, хорогдол	1,349,651,145.15	1,512,733,190.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	251,272,732.61	260,445,948.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	233,478,769.00	205,155,446.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	233,478,769.00	205,155,446.00
2133	Улсын төсвээс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,793,963.61	55,290,502.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,793,963.61	55,290,502.99
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,175,240,020.16	10,553,440,026.06
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		13,417,045,474.97
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		21,394,594.13
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		13,395,650,880.84
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,175,240,020.16	(2,863,605,448.91)

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙТАЙЛАН

2017 он 12 сар 31 өдөр.

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	20,184,214,237.54	19,734,480,337.73
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	394,597,160.79	19,734,480,337.73
120	Нийтлаг татварын бус орлого	394,597,160.79	19,734,480,337.73
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	394,597,160.79	170,504,917.05
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	331,130,870.00	155,603,803.01
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	63,466,290.79	14,901,114.04
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	19,769,617,076.75	19,563,975,420.68
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	16,348,549,700.00	16,769,309,900.00
131001	Ургал үйл ажиллагааны санхүүжилт	16,348,549,700.00	16,769,309,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,833,167,376.75	1,810,004,320.68
131101	Төрийн болон орон нутгийн имчт бус этгээдээс авсан хандив, тусламж		1,571,857,013.68
131102	Төсвийн жилийн явцад УИХаас соёрхон баталсан ЗГ хоорондын гэрээ болон ОУбайгуул	2,833,167,376.75	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвее доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		156,481,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		81,665,707.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	587,900,000.00	984,661,200.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	587,900,000.00	984,661,200.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20,144,180,677.54	19,621,290,837.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20,144,180,677.54	19,621,290,837.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,692,869,104.93	18,937,944,488.74
2101	Цалин хэлс болон нэмэгдэл урамшил	9,717,137,747.00	9,760,697,476.00
210101	Үндсэн цалин	7,863,664,777.00	6,219,385,500.00
210102	Нэмэглэл		1,703,241,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	710,899,200.00	703,790,200.00
210104	Урамшуулал	1,142,573,770.00	1,134,280,776.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтэл	1,110,774,100.00	1,145,453,200.00
210201	Тэтгэврийн даатгал	1,110,774,100.00	1,145,453,200.00
210202	Тэтгэмхийн даатгал		
210203	ҮОМШ-ний даатгал		
210204	Ажилгүйдлийн даатгал		
210205	Эрүүл мэндийн даатгал		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	862,879,800.00	983,978,820.00
210301	Гэрэл, цахилгаан	327,904,090.57	357,537,094.00
210302	Тулиш, халаалт	269,891,860.43	315,289,406.00
210303	Цэвэр, бокир ус	265,083,849.00	284,446,400.00
210304	Байрны түрээс		26,705,920.00
2104	Хангамж, бараа материалын зардал	868,807,738.53	588,819,912.56
210401	Бичиг хэрэг	117,723,424.00	116,705,355.00
210402	Тээвэр, шатахуун	611,592,300.99	297,906,663.00
210403	Шудан, холбоо, интернэтийн төлбөр	21,518,238.54	26,080,534.56
210404	Ном, хэвлэл	54,000.00	19,735,000.00
210405	Хог хаягдал зайлзуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	85,753,905.00	110,949,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	32,165,870.00	15,442,560.00
2105	Нормативт зардал	5,962,496,079.40	5,676,241,740.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,065,186,540.00	4,814,068,870.00
210502	Хоол, хүнс	797,859,539.40	764,900,820.00



210503	Нормын хувцас, зөвлөн здлэл	99,450,000.00	96,272,050.00
2106	Эд хогшил, ургал засварын зардал	94,422,362.00	157,250,296.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	36,175,200.00	37,363,393.00
210602	Тавилга	5,528,940.00	13,905,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,166,400.00	3,777,800.00
210604	Ургал засвар	49,551,822.00	102,204,103.00
2107	Томилолт, зочны зардал	540,784,727.00	295,977,050.00
210701	Гадаад албан томилолт		41,400,000.00
210702	Дотоод албан томилолт	540,784,727.00	254,577,050.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	535,566,551.00	332,525,994.18
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	497,691,897.00	293,412,976.18
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,221,318.00
210803	Даатгалын үйлчилгээ	939,384.00	1,108,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,201,700.00	2,160,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	64,170.00	269,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		
210807	Газрын төлбөр	8,456,200.00	8,371,600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, балтгэх	23,213,200.00	22,981,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	451,311,572.61	683,346,348.99
2132	Бусад ургал шилжүүлэг	233,478,769.00	428,955,446.00
213204	Ажил олгогчос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	233,478,769.00	205,155,446.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал		223,800,000.00
2133	Улсын төсөөвөө олгосон санхүүжилт, шилжүүлэг	217,832,803.61	254,390,902.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	217,832,803.61	254,390,902.99
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	20,033,560.00	113,189,500.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	20,033,560.00	113,189,500.00
22	ХӨРӨНГҮЙН ЗАРДАЛ	20,033,560.00	113,189,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	20,033,560.00	113,189,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,033,560.00	113,189,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(20,033,560.00)	(113,189,500.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

01

ТЕРИЙН АУДИЛЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДУГНЭЛТ

Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 1-р сарын 1-нээрх Улдэгдэл	9,674,240,769.60	6,471,953,283.43	10,965,614,581.16	27,111,808,634.19
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(6,751,929,102.00)	(6,751,929,102.00)
Дахин илэрхийлсэн Улдэгдэл	9,674,240,769.60	6,471,953,283.43	4,213,685,479.16	20,359,879,532.19
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсвөлт буураат				
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсан дүн				
Үндсэн хөрөнгийн өсвөлт буураат Сорлогтын тайланц хулзэн зөвшөөрөөгүй олз. гарз				
Тайлант чийн үр дүн	-	-	3,175,240,020.16	3,175,240,020.16
2016 оны 12-р сарын 31-нээрх Улдэгдэл	9,674,240,769.60	6,471,953,283.43	7,388,925,499.32	23,535,119,552.35
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	9,674,240,769.60	6,471,953,283.43	7,388,925,499.31	23,535,119,552.34
Дахин илэрхийлсэн Улдэгдэл	9,674,240,769.60	6,471,953,283.43	24,159,861.03	24,159,861.03
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсвөлт буураат Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсан дүн				
Үндсэн хөрөнгийн өсвөлт буураат Сорлогтын тайланц хулзэн зөвшөөрөөгүй олз. гарз				
Тайлант чийн үр дүн				
2017 оны 12-р сарын 31-нээрх Улдэгдэл	9,674,240,769.60	6,471,953,283.43	7,413,085,360.34	23,559,279,413.37
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсан дүн				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсвөлт буураат Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсан дүн				
Сорлогтын тайланц хулзэн зөвшөөрөөгүй олз. гарз				
Тайлант чийн үр дүн				
2017 оны 12-р сарын 31-нээрх Улдэгдэл	9,674,240,769.60	6,447,793,422.40	4,549,479,911.43	20,671,514,103.43

01

**ТӨРИЙН АУДИТИН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДУТНЭЛТ**


Байгууллагын нэр: Халдварт өвчин судлалын үндэсний төв

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2017 он 12 сар 31 өдөр.

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,995,890,200.00	17,924,476,017.05	71,414,182.95	99.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,995,890,200.00	17,924,476,017.05	71,414,182.95	99.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,448,014,400.00	17,440,623,798.74	7,390,601.26	99.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,545,443,500.00	9,545,443,500.00	-	100.00
210101	Үндсэн цалин	6,214,886,700.00	6,214,886,700.00	-	100.00
210102	Нэмэгдэл	1,703,241,000.00	1,703,241,000.00	-	100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	703,790,200.00	703,790,200.00	-	100.00
210104	Урамшуулалт	923,525,600.00	923,525,600.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,145,453,200.00	1,145,453,200.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтолц зордал	957,272,900.00	957,272,900.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	358,623,100.00	357,537,094.00	1,086,006.00	99.70
210302	Туслэл, халаалт	314,203,400.00	315,289,406.00	(1,086,006.00)	100.35
210303	Цэвэр, бохир ус	284,446,400.00	284,446,400.00	-	100.00
210304	Байрны түрээс	-	-	-	-
2104	Хангамж, бараа материалын зордал	253,140,100.00	253,140,099.56	0.44	100.00
210401	Бичиг хэрэг	16,856,100.00	16,856,100.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	81,257,800.00	81,257,800.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,426,800.00	20,426,799.56	0.44	100.00
210404	Ном, хэвлэл	-	-	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	110,949,800.00	110,949,800.00	-	100.00
210406	Бага үнэтай, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,649,600.00	23,649,600.00	-	100.00
2105	Нормативт зордал	5,359,125,900.00	5,359,125,900.00	-	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслэл	4,737,795,900.00	4,724,970,950.00	12,824,950.00	99.73
210502	Хоол, хүнс	537,882,900.00	537,882,900.00	-	100.00
210503	Нормын хувцас, зөвлөн эдлэл	83,447,100.00	96,272,050.00	(12,824,950.00)	115.37
2106	Эд хогшил, урсгал засварын зордал	83,585,100.00	83,584,500.00	600.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	35,962,200.00	35,962,200.00	-	100.00
210602	Тавилга	-	-	-	-
210603	Хедөлмер хамгааллын хэрэглэл	3,777,800.00	3,777,800.00	-	100.00
210604	Урсгал засвар	40,728,600.00	40,728,000.00	600.00	100.00
210701	Гадаад албан томилолт	-	-	-	-
210702	Дотоод албан томилолт	3,116,500.00	3,116,500.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	103,993,700.00	96,603,699.18	7,390,000.82	92.89
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,212,000.00	57,490,681.18	721,318.82	98.76
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,890,000.00	4,221,318.00	6,668,682.00	38.76
210803	Даатгалын үйлчилгээ	1,108,800.00	1,108,800.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,160,900.00	2,160,900.00	-	100.00



210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	269,300.00	269,300.00	-	100.00
210807	Газрын төлбөр	8,371,600.00	8,371,600.00	-	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	22,981,100.00	22,981,100.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	547,875,800.00	483,852,218.31	64,023,581.69	88.31
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	277,077,800.00	205,155,446.00	71,922,354.00	74.04
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	270,798,000.00	223,800,000.00	46,998,000.00	82.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		54,896,772.31	(54,896,772.31)	
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ YYCSBЭР	17,995,890,200.00	17,924,476,017.05	71,414,182.95	99.60
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	16,841,229,000.00	16,769,309,900.00	71,919,100.00	99.57
310001	Улсын төсвөөс санхүүжих	16,841,229,000.00	16,769,309,900.00	71,919,100.00	99.57
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	984,661,200.00	984,661,200.00	-	100.00
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	984,661,200.00	984,661,200.00	-	100.00
35	ТӨСӨВӨТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	170,000,000.00	170,504,917.05	(504,917.05)	100.30
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	104,000,000.00	155,603,803.00	(51,603,803.00)	149.62
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	66,000,000.0	14,901,114.05	51,098,885.95	22.58
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	
610001	Төсвийн байгууллага	1	1	0	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	746	746	0	100.00
620001	Удирдах ажилтан	7	7	0	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	493	493	0	100.00
620003	Үйлчлэх ажилтан	246	246	0	100.00
620004	Гэрээт ажилтан	0	0	0	

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН / нэмэлт данс/

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР	1,610,510,280.15	1,810,004,320.68	-199,494,040.53	88.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,610,510,280.15	1,810,004,320.68	-199,494,040.53	88.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ	1,610,510,280.15	1,610,510,190.00	90.15	0
2101	Цалин хэлс болон нэмэгдэл	215,253,976.00	215,253,976.00	-	100.00
210101	Үндсэн цалин	4,498,800.00	4,498,800.00	-	100.00
210104	Урамшуулал	210,755,176.00	210,755,176.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоот	26,705,920.00	26,705,920.00	-	100.00
210304	Байрны түрээс	26,705,920.00	26,705,920.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалы	341,886,943.00	341,886,853.00	90	100.00
210401	Бичиг хэрэг	99,849,255.00	99,849,255.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	216,648,953.00	216,648,863.00	90	100.00
210403	Шуудан, холбоо, интернатий	5,653,735.00	5,653,735.00	-	100.00
210404	Ном, хэвлэл	19,735,000.00	19,735,000.00	-	100.00
2105	Нормативт зардал	353,915,840.00	353,915,840.00	-	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэр	126,897,920.00	126,897,920.00	-	100.00
210502	Хоол, хүнс	227,017,920.00	227,017,920.00	-	100.00
2106	Эд хогшил, ургсал засварын	430,630,246.15	430,630,246.00	0.15	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,388,593.00	13,388,593.00	-	100.00
210602	Тавилга	62,905,000.53	62,905,000.00	0.53	100.00
210603	Хедэлмэр хамгааллын хэрэглэл			-	
210604	Ургсал засвар	61,476,102.62	61,476,103.00	-0.38	100.00
210701	Гадаад албан томилот	41,400,000.00	41,400,000.00	-	100.00
210702	Дотоод албан томилот	251,460,550.00	251,460,550.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	242,117,355.00	242,117,355.00	-	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн буса	242,117,355.00	242,117,355.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖКҮҮЛЭГ	-	199,494,130.68	-199,494,130.68	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		199,494,130.68	-199,494,130.68	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖКҮҮЛЭХ	1,610,510,280.15	1,810,004,320.68	-199,494,040.53	88.98
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮ	-	-	-	
37	Нэмэлт санхүүжилтын орло	1,610,510,280.15	1,810,004,320.68	-199,494,040.53	88.98
131104	Төрийн болон орон нутгийн	1,610,510,280.15	1,810,004,320.68	-199,494,040.53	88.98
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөр	-	-	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөр	0	0	0	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	
610001	Төсвийн байгууллага	1	1	0	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	746	746	0	100.00
620001	Удирдах ажилтан	7	7	0	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	493	493	0	100.00
620003	Үйлчлэх ажилтан	246	246	0	100.00
620004	Гэрээт ажилтан	0	0	0	

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг

Бага тойруу-3, Засгийн газрын IV байр

Утас:26-04-37, Факс:62-26-32-30

